

## ӨМНӨХ ҮГ

ШУА-ийн Хими, химийн технологийн хүрээлэнгээс эрхлэн гаргадаг Эрдэм шинжилгээний бүтээл сэтгүүлийн 2019 оны дугаарыг та бүхэнд хүргэж байна.

Эрдэм шинжилгээний бүтээл сэтгүүл (*Bulletin of Institute of Chemistry and Chemical Technology*, ВИССТ) нь 2018 оны дугаараас эхлэн Mongolia Journals Online ([www.mongoliajo.info](http://www.mongoliajo.info))-д нэгдэн орсон. Одоогоор Google scholar, Dimensions, CNKI Scholar зэрэг хайлтын төрөлжсөн системүүдэд бүртгэлтэй болж, байнгын хянан магадлагаа хийгдэн хэвлэгдэж байгааг дуулгахад таатай байна. 2019 онд ЭШБ сэтгүүлд хэвлэгдсэн өгүүллүүд нийт 27865 удаа татагдаж олон нийтийн хүртээл болжээ.

ЭШБ сэтгүүлийн энэ удаагийн дугаарт нийт 14 эрдэм шинжилгээний өгүүлэл хүлээн авч хөндлөнгийн хянан магадлагаа хийгдэн 10 өгүүлэл энэхүү дугаарт хэвлэгдэн гарч байна. Эдгээр өгүүллийн 4 нь байгалын нэгдлийн хими, 3 нь органик бус хими, материал судлал, 1 нь рашаан ба гидрохими, 2 нь хүнс болон биологийн идэвхт нэгдлийн чиглэлд хамаарагдаж байна.

Манай сэтгүүлийн энэ удаагийн дугаарт зохиогч судлаачдын өөрсдийн эрдэм шинжилгээний үр дүнгээс гадна бусад судлаачдын судалгааны дүнг нэгтгэсэн 2 тойм өгүүлэл хэвлэгдсэн нь онцлог болсон бөгөөд судлаач Э.Нямсүрэн, доктор Г.Одонтуяа нарын ургамлын химийн чиглэлээр бичсэн тойм өгүүллүүдэд ургамлын өвөрмөц бүрэлдэхүүн болох фенилэтаноид гликозидийн молекулын бүтцийн онцлог, тэдгээрийн биолог, фармакологийн идэвхийн судалгааны дүн болон уламжлалт анагаах ухаанд хэрэглэдэг ургамлуудын талаарх угсаатны эм судлалын мэдлэг, мэдээллүүдийг нэгтгэн бичжээ. Эдгээр өгүүллүүд нь ургамлаас эмийн идэвхт зорилтот бодисуудыг гарган авах болон тэдгээрийн хэрэглээний чиг хандлагыг тодорхойлсон чухал ач холбогдолтой ажлууд болсон байна.

Түүнчлэн, судлаач Чжуо Фугуан нарын “Рүда ургамлын (*Aucklandia lappa* Desne.) терпент нэгдлийн судалгаа” өгүүлэлд уламжлалт эмийн ургамлын үндэснээс ялгасан нэгдлүүдийг ЦСР спектроскопийн аргаар тодорхойлж устөрөгч ба нүүрстөрөгчийн атомуудын химийн шилжилтийн утгуудад оноолт хийсэн нь уг ургамлын биологийн идэвхийг тогтооход чухал ач холбогдолтой ажил болжээ. Судлаач Н. Жавзмаа нарын “Ямаан арц (*Juniperus sibirica*) ургамлын эфирийн тосны химийн бүрэлдэхүүн, бичил биетний эсрэг, хөхний хорт хавдрын (MCF 7) эсийн өсөлтийг дарангуйлах идэвхийн судалгаа” сэдэвт өгүүлэлд Монгол орны ямаан арцны эфирийн тосны химийн бүрэлдэхүүн, биологийн идэвхийн уялдаа холбоог тодорхойлж, хэрэглээний үндэслэлийг бий болгосон байна.

Судлаач Б.Өнөрсайхан, Ц.Загарзүсэм, доктор Ц.Золзаяа нарын эрдэс түүхий эдийн чиглэлээр хийсэн судалгааны үр дүнгээр бичсэн “Чандмань-Уул ордын төмрийн хүдрийг хуурай соронзон болон нойтон соронзон аргаар баяжуулах технологийн судалгаа” ба “Манганы хүдрийг гравитацийн аргаар баяжуулах технологийн судалгаа”, “Бодончийн голын гялтгануурын найрлага, шинж чанарын судалгаа” өгүүллүүдэд Монгол орны төмөр, манганийн хүдэр, гялтгануурын найрлага, шинж чанарыг судалж, тэдгээрийг баяжуулах технологийн талаар үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

Харин хүнсний химийн чиглэлээр судлаач Б.Мөнхцэцэг нарын “Чацаргана (*Hipporhae ghamnoides* L.) жимсний хальснаас гарган авсан биологийн идэвхт бэлдмэлийн хорон чанарын судалгаа” өгүүлэлд хаягдал түүхий эдээс биологийн идэвхт нэмэлт бүтээгдэхүүн гарган авах боломж, түүний хоруу чанарын судалгаа, доктор Н.Эрдэнэчимэг нарын “Хүнсний бүтээгдэхүүнд түргэвчилсэн аргаар тосны хүчлийн транс-изомер тодорхойлох боломж” сэдэвт өгүүлэлд өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн дэх транс тосны агууламжийг гэрлийн бүрэн ойлтын нэмэлт төхөөрөмж бүхий нил улаан туяаны спектрийн (ATR-FTIR) түргэвчилсэн аргаар тодорхойлсон үр дүнгүүд оржээ.

Рашаан ба гидрохимийн чиглэлээр хийсэн судалгааны үр дүнгийн тухай судлаач Ч.Болормаа нарын “Завхан аймгийн халуун рашаануудын химийн найрлага, геотермометрийн

судалгаа” сэдэвт өгүүлэлд Завхан аймгийн халуун рашаануудын гидрохимийн найрлага, газрын гүний халуун усны температур болон гүнийг тогтоож, тэдгээрийг хүлэмж, бассейн, байр орон сууцны халаалтад шууд хэрэглэх болон бинары системийг ашиглан эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах боломжтой гэж үзсэн байна.

Тус “Эрдэм шинжилгээний бүтээл” сэтгүүлд бүтээлээ ирүүлсэн нийт судлаачид болон шүүмж хийж бүтээлийн чанарыг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулж буй шүүмжлэгч нартаа талархал илэрхийлж, та бидний хамтын ажиллагаа Монгол улсад химийн болон салбар дамнасан шинжлэх ухааныг хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

Улс орны хөгжлийн түлхүүр болсон Монгол улсын шинжлэх ухаан хөгжин цэцэглэх болтугай.

ЕРӨНХИЙ РЕДАКТОР Л. ЖАРГАЛСАЙХАН  
С. ЭНХТУУЛ

---

DOI: <https://doi.org/10.5564/bicct.v0i7.1265>